



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 07 өдөр

Дугаар A/31

Мандалговь


Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай

Монгол улсын Газрын тухай хуулийн 38 дугаар зүйл 38.1,2,4 дэх заалт, газар эзэмших эрхийг шилжүүлэн авах иргэний хүсэлтийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

Нэг. Сайнцагаан сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэр (Нарлаг-4-405a)-т байршилтай Баяраа овогтой Буяннэмэх (ЗЮ:70102870)-ийн орон сууц зориулалттай 144м.кв (0,01га) газрыг Эрдэнэбат овогтой Мөнгөнзаяа (ЗФ:88022404)-д зориулалтаар нь шилжүүлж 22 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

Хоёр. Дээрх иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (Р.Мөнхтогтох), аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат) нарт үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2014 оны 06 дугаар сарын 20-ний өдрийн А/377 дугаар захирамжийн иргэн Б.Буяннэмэх-д холбогдох хэсэг мөн газар эзэмших 000505586 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.



482016080